

## ТАНИЛЦУУЛГА

Шимтгэлийн доод хэмжээг батлах тухай  
тогтоолын төслийн тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-т “хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн”, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт “Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажиллаж байгаа Монгол Улсын иргэний төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно” гэж заасан.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай” 05 дугаар тогтоолоор 40 000 воноос багагүй байхаар баталсан.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2008 оны 19 дүгээр тогтоолоор Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээг 40 000 воноор анх тогтоосон бол 2014 оны 20 дугаар тогтоол, 2018 оны 05 дугаар тогтоолуудаар тус тус 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан ч нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ өөрчлөгдөөгүй. 2008 оноос хойш өнөөдрийг хүртэл мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хууль болох Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг тус тус хэлэлцэн баталсан бөгөөд хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 7.3.3-т заасан Монгол Улсын иргэний төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно” гэж заасан.

Монгол Улсын Засгийн газраас гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийнхээ нийгмийн баталгааг хангах зорилгоор Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс (ОХУ), Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Унгар Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Польш Улс зэрэг нийт 6 улстай нийгмийн хамгааллын хэлэлцээрийг тус тус байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Эдгээр улс бүрийн хэлэлцээр өөр өөр агуулгатай бөгөөд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн “Шимтгэлийн хэмжээг тогтоох тухай” тогтоолын төсөл нь зөвхөн Бүгд Найрамдах Солонгос Улсад хамаарах юм. Бусад улсын хувьд нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ тогтоогддоггүй бөгөөд тухайн улсын хууль

тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж авах боломжийг нь бүрдүүлэх, хоёр улсад ажиллан нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож тухайн улсуудаас ногдох тэтгэврийг авах, тэтгэврийг харилцан шилжүүлэх зэрэг асуудлуудыг шийдэж байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасаг нь 2007-2022 оны хугацаанд Монгол Улсын нийгмийн даатгалын санд Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр болон бусад хэлбэрээр хөдөлмөр эрхэлж буй иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого нийт 19.8 тэрбум вон буюу 34.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. Өнгөрсөн онд Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөр эрхэлж байгаа иргэдээс нийгмийн даатгалын санд нийт 2.5 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна.

2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Бүгд Найрамдах Солонгос Улсад Монгол Улсын 53.0 мянган иргэн оршин сууж байна. Үүнээс хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэд 4.3 мянга, түр хугацааны визтэй иргэд 20.2 мянга, байнгын оршин суугч 0.7 мянга, оюутан 8.1 мянга, Солонгос иргэнтэй гэр бүл болсон 2.0 мянга, гэр бүлийн визтэй 3.9 мянган иргэн байгаагаар тус тус бүртгэгдсэн байна.

2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар тэтгэврийн даатгалд даатгуулсан, мэдээллийн санд бүртгэлтэй нийт 24.0 мянган иргэн байна. Үүнээс ажиллаж байгаа 4.3 мянган иргэн, нутаг буцсан 18.9 мянга, харласан болон тодорхойгүй байгаа 0.8 мянган иргэн байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэг цагт 9620 вон (25782 төгрөг)<sup>1</sup>, буюу сард 2 010 580 вон (5 388 354 төгрөг) байхаар, Монгол Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэг цагт 3273 төгрөг 81 мөнгө буюу сард 550 000 төгрөг байхаар тус тус тогтоосон. Аж ахуй нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2022 оны байдлаар 1 503 800 төгрөг байна. Үүнтэй уялдуулан хөдөлмөрийн гэрээгээр Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллаж байгаа Монгол Улсын иргэний төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээг 50 000 (тавин мянга) вонноос багагүй байхаар Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын төслийг боловсрууллаа.

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол батлагдсанаар улсын болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй бөгөөд хуулийн ямар нэгэн зөрчил үүсгэх зүйл заалт агуулагдаагүй болно.

---oOo---

---

<sup>1</sup> 10 дугаар сарын воны ханш-2.68